


- Орос, Япон улсууд Монголын асуудлаар хэзээ нууц гэрээ байгуулсан бэ?
 А. 1861 он В. 1907 он С. 1908 он D. 1911 он
- Манж Чин гүрний “Шинэ засгийн бодлого” монголчуудын ямар эрх ашгийг илүүтэй хөндөж байсан бэ?
 А. Монголд хятад иргэдийг олноор суурьшуулж эхэлсэн
 В. Сургууль байгуулж, сонин гаргах болсон
 С. Цэргийн зохион байгуулалтыг өөрчилсөн
 D. Засаг захиргааны хуваарийг өөрчилсөн

3. Түүхэн эх сурвалжид өгүүлэгдэж буй үйл явдал өрнөсөн газар нутгийг өгөгдлөөс сонгоорой.

“...Мөнөөхөн өвлийн дунд сарын шинийн есөн болж ирэв. Мөнхүү өглөө чуулганы даргын жасааны түшмэл, бичээч нарын хамт залан Дашдондов, Анваан нар малгай, хүрэм болон Их Хүрээний төвийн шар ордны тэнд очиж, мориноос буугаад их хаалганы өмнө хүрэхэд олон хүн хуралдаж, үнэхээр нүд алдам их байв...”



- A. A
- B. B
- C. C
- D. D

4. 1921 оны үндэсний ардчилсан хувьсгал “олноо өргөгдсөн”-ий хэдэн онд ялсан бэ?

Он тооллын шугам



- A. 9-р он В. 10-р он С. 11-р он D. 21-р он

5. 1921 оны зунаас “Үндсэн хууль”-ийн төсөл боловсруулж эхэлсэн түүхэн зүтгэлтнийг сонгоно уу.

- A. С. Данзан В. Д.Сүхбаатар С. Д. Бодоо D. Д.Магсаржав

6. Монгол Ардын Нам хэдэн оноос Монгол Ардын Хувьсгал Нам нэртэй болсон бэ?
 A. 1925 он B. 1928 он C. 1921 он D. 1924 он

7. 1924 онд болж өрнөсөн үйл явдлуудыг зөв ялгасан хувилбарыг сонгоно уу.

1. Д.Бодоог улс төрийн хэрэгт холбогдуулж цаазаар авав.
2. Улсын анхдугаар их хурал хуралдав
3. Монгол улс хэмжээт эрхт хаант засаглалд шилжив.
4. Хамжлагат ёсыг халах шийдвэр гарав.
5. Анхдугаар үндсэн хууль батлагдав.
6. Улсын нийслэлийг Улаанбаатар гэж нэрлэв.

- A. 1,2,5 B. 1,3,4 C. 3,5,6 D. 2,5,6

8. 1924 оны үндсэн хуулиар Монгол улсын иргэдийг сонгох, сонгогдох эрхтэй болон сонгох, сонгогдох эрхгүй хүмүүс хэмээн ангилжээ. Сонгох ба сонгогдох эрхгүй иргэдэд хамаарахыг олно уу.

- A. Угсаа сурвалжгүй, ядуу ардууд
- B. Ямагт ашгийг эрмэлзэж бусдыг зарж мөлжин амьдрагчид
- C. Өртөө, харуулын албыг гүйцэтгэж байсан суман ардууд
- D. Монгол ноёдын хамжлага байсан ардууд

9. Мэдээллийг уншиж, хэдий үед өрнөсөн үйл явдлын тухай өгүүлж буйг тодорхойлно уу.

“...Үндсэн хуулиар олгосон шүтэх, бишрэх эрхээ эдлэх боломжгүй болж, өмч хөрөнгөө хураалгасан иргэд нам, төрийн буруу бодлогод дургүйцэж байв. Мөн большевикууд Монголын дотоод хэрэгт хэтэрхий хутгалдан оролцож, Монголд социализм байгуулж болох эсэхийг туршиж буйг эсэргүүцэж байв...”

(С.Амарсанаа нар. Түүх IX. УБ., 2018. т. 66)

- A. 1924-1928 он B. 1928-1932 он C. 1932-1936 он D. 1936-1940 он

10. 1926 оны байдлаар гадаадад нийт хэчнээн тооны Монгол оюутан, залуус боловсрол эзэмшиж байсан бэ?

- A. 150 орчим B. 200 орчим C. 250 орчим D. 300 орчим

11. 1952 оноос олгож эхэлсэн одон аль нь вэ?

A.



B.



C.



D.



12. Он тооллын шугамыг ажиглаж, тэмдэглэгдсэн үйл явдал хэддүгээр зууны аль хагаст холбогдохыг тодорхойлно уу.

Он тооллын шугам



- А. XVIII зууны II хагас
 С. XIX зууны II хагас

- В. XIX зууны I хагас
 D. XX зууны I хагас

13. Цэгийн оронд тохирох нэрийг сонгон уу.

БНМАУ-ын үед урлаг, соёлын талаар бодитой амжилт олж байсан. Гэвч нэг намын хэт үзэл сурталжуулах нөлөөний дор сэтгэлгээний эрх чөлөөг боогдуулах, үйл ажиллагааны хүрээг зааж нэг загварт оруулах, хуулбарлах, даган дууриах явдал газар авахад хүргэж байв. Тухайлбал, түүх, соёлоо өмгөөлж, хүний эрх, сэтгэлгээний эрх чөлөөг магтан дуулсан- н шүлэг, найраглалыг хааж байв.

- А. Д.Нацагдорж В. С.Эрдэнэ С. Д.Намдаг D. Р.Чойном

14. Япон улс өөрийн улс төрийн бодлогыг хэрэгжүүлэх зорилгоор 1932 онд ямар улсыг байгуулсан бэ?

- А. Нармай Монгол В. Манж го улс С. БН Тува улс D. Тайван улс

15. Номун хан, Бүрдэн Овооны чиглэлээр Япон-Манж Гогийн миномёт, пулемётоор дэмжүүлсэн 200 цэрэг бүхий салбарууд хилээс дотогш холгүй зайд орших Бойтогт манханд үүрэг гүйцэтгэж байсан 10 хүний бүрэлдэхүүнтэй хилийн харуул руу дайрсан үйл явдлыг юуны эхлэл гэж үзсэн бэ?


- А. Байтаг богдын байлдаан В. Халхын голын байлдаан
 С. Чөлөөлөх дайн D. Хар тамхины дайн

16. Адилтгах замаар асуултын тэмдгийн оронд тохирох өгөгдлийг сонгоно уу.

- а. Тэнхлэгийнхэн - Герман, Итали, Япон
 б. Холбоотнууд - ?

- А. Их Британи, Франц, Польш
 В. ЗХУ, Польш, Монгол
 С. Казакстан, Унгар, ЗХУ
 D. Их Британи, Франц, ЗХУ, АНУ

17. Газар зүйн зургийг ажиглаж “Дэлхийн II дайн”-ы дараа холбоотнууд Германыг хуваахдаа 2, 4 тоогоор тэмдэглэсэн газар нутгийг ямар улсууд өөрийн нөлөөнд авсан бэ?



- а.  ЗХУ
- б.  Франц
- в.  АНУ
- г.  Их Британи

А. а, в

В. б, в

С. а, г

Д. б, г

18. ЗХУ-ын нөлөө гүнзгийрснээр Монголд ямар үйл явдал өрнөхөд түлхэц болсон бэ?

- А. Үндэсний ардчилсан хувьсгал өрнөсөн
В. Бүгд найрамдах засаглалд шилжсэн
С. Их хэлмэгдүүлэлт
Д. Ардчилсан хувьсгал

19. Олноор хоморголон баривчлах үйл ажиллагаа хэзээ эхэлсэн бэ?

- А. 1936 оны 9 сарын 10
В. 1937 оны 9 сарын 10
С. 1924 оны 9 сарын 10
Д. 1939 оны 9 сарын 10

20. Доорх хөшөөнд холбогдох үйл явдлыг ямар байгууллага удирдан зохион байгуулсан бэ?



- А. Коментерний гүйцэтгэх хорооны тусгай комисс
В. Ардын засгийн газар
С. Онцгой бүрэн эрхт комисс
Д. Улсын бага хурал

21. Доорх эх сурвалжийн мэдээтэй хамаарал бүхий түүхэн зүтгэлтнийг сонгоно уу.

“...Би Монголын ард түмэндээ хайртай, би Оросын ард түмэнд элэгтэй, харин улаантан, тэдний засагт дургүй. Учир нь тэд аливаа том гүрний нэгэн адил Монгол улсыг эзлэн түрэмгийлэх бодлого явуулж байна...”

A.



Д.Сүхбаатар

B.



Х.Чойбалсан

C.



П.Гэндэн

D.



А.Амар

22. Их хувьчлалын цэнхэр тасалбараар юуг хувьчилсан бэ?

A. Томоохон үйлдвэрүүдийг

B. Мал

C. Малын бэлчээр

D. Үйлдвэрлэл үйлчилгээний жижиг нэгжүүд

23. Дараах онуудаас аль онд УИХ-ын ээлжит сонгууль болсон бэ?

A. 1994 он

B. 1996 он

C. 1998 он

D. 2002 он

24. “Аз болж хонх дуугарлаа, арай ядан нойрноос сэвлээ” дууны шүлгийн мөрүүд нийгмийн аль үеийг төлөөлж байна вэ?

A. 1990 оны хувьсгалын дараах үе

B. 1990 оны хувьсгалын өмнөх үе

C. 1921 оны хувьсгалын өмнөх үе

D. 1921 оны хувьсгалын дараах үе

25. 1989 оны 12 сарын 10-нд Монголд олон нийтийг хамарсан улс төрийн жагсаалыг хаана зохион байгуулсан бэ?



A. 1

B. 2

C. 3

D. 4